

## АЗИ ТИВИЙН СҮҮ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫН ГАЗРЫН ЗОХИЦУУЛАГЧИЙН АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА.

НҮБ-ын Хүнс, хөдөө ахуйн байгууллагаас санаачлан “Dairy Asia” Ази тивийн сүү үйлдвэрлэлийн индэрийг 2014 онд үүсгэн байгуулсан. Энэ санаачилгад одоогоор Ази тивийн 13 улс нэгдэж ороод байна. Үүнд: Монгол, Тайланд, Хятад, Шри Ланк, Бутан, Бангладеш, Индонези, Афганистан, Филиппин, Энэтхэг, Мьянмар, Непал, Вьетнам.

“Ази тивийн сүү үйлдвэрлэл” индэрийн үйл ажиллагааг тогтмолжуулах, цар хүрээг нь өргөтгөх, гишүүнчлэлийг нэмэгдүүлэх, Ази тивд сүү үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх зорилгоор Нарийн бичгийн дарга нарын газрыг Улаанбаатар хотод байгуулах талаар Засгийн газрын 2020 оны 11 дүгээр тогтоол батлагдсан. Энэ тогтоолын хүрээнд Ази тивийн сүү үйлдвэрлэлийн Нарийн бичгийн дарга нарын газрын зохицуулагч (Dairy Asian Coordinator)-ийн ажлын байр НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарлагдлаа.

Зарыг <http://www.fao.org/mongolia/news/detail-events/en/c/1264403/> хаягаар татаж үзнэ үү.

Ази тивийн сүү үйлдвэрлэлийн Нарийн бичгийн дарга нарын газрыг Улаанбаатар хотод байгуулснаар Монгол Улсад төдийгүй Ази тивийн бүс нутагт дараах ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

1. Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн салбарын гадаад харилцаа хөгжиж шинэ шатанд гарна. Монгол Улсын сүүний салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тогтвортой хөгжлийг хангах нөхцөл, боломж бүрдэнэ. Цаашид урт хугацаанд сүү, сүүн бүтээгдэхүүнийг бүс нутгийн болон олон улсын зах зээлд экспортлоход Монгол Улсын имиж төрхийг бүрдүүлж, стратегийн хувьд өргөн бололцоо нээгдэнэ.

2. Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын олон улсын судалгааны институтын дараа Монгол Улсад төвтэй олон улсын 2 дахь институц бий болж, гадаад харилцаанд эерэг нөлөө үзүүлнэ. Монгол Улсын гадаад нэр хүнд бэхжинэ.

3. Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлого, хөдөө аж ахуйн салбарын идэвхтэй хамтын ажиллагаанд түшиглэн Төв Ази, зүүн хойд Ази, Баруун Азийн бүс нутгийн улс орнуудыг гишүүнээр элсүүлэх, Нарийн бичгийн дарга нарын газрын үйл ажиллагааг өргөтгөн зохион байгуулах нөхцөл, боломж бүрдэнэ.

4. Ази тивийн бүс нутагт зөвхөн сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй төдийгүй ингэ, гүү, хонь, ямааны сүү үйлдвэрлэлийг дэмжих, эрчимжсэн болон уламжлалт мал аж ахуйг хослуулах, сүү, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн болон нэмүү өртгийн сүлжээг тогтвортой хөгжүүлэхэд түлхэц болно.

Ази тивийн сүү үйлдвэрлэлийн Нарийн бичгийн дарга нарын газраас дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Нарийн бичгийн дарга нарын газрын дүрмийг боловсруулах, институцийн чадавхийг бэхжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

2. Эхний шатанд Зүүн Азийн Япон, БНСУ, БНАСАУ, дараагийн шатанд Төв Азийн Казакстан, Киргизстан, Узбекистан, Тажикстан, Туркменистан, урт хугацаанд Ази тивийн бусад улс орнуудад гишүүнчлэлийн санал тавих, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
3. Ази тивд сүү үйлдвэрлэлийг үндэсний болон бүс нутгийн түвшинд нэмүү өртгийн сүлжээгээр нь хөгжүүлэх техник туслалцааны төслийн санал боловсруулах, хамтран хэрэгжүүлэх саналыг Азийн хөгжлийн банк /ADB & CAREC/, Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны агентлаг /ЖАЙКА/, БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны агентлаг /КОЙКА/ зэрэг байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
4. Ази тивийн сүү үйлдвэрлэл, хэрэглээний ач холбогдлыг бүс нутаг, олон улсад бодитой сурталчлан таниулах зорилгоор “Dairy Asian ambassador” нийгэм, соёлын элч төлөөлөгчдийг өргөмжлөх, хамтран ажиллах;
5. Ази тивийн сүү үйлдвэрлэлийн салбарт харилцан туршлага солилцох нөхцөл, боломжийг бүрдүүлэх, хувийн хэвшлийн оролцоог дэмжих, урамшуулах зорилгоор дараах номинацийг шинээр бий болгох. Үүнд:
  - a. Dairy Asian best farm;
  - b. Dairy Asian best factory;
  - c. Dairy Asian best management;
  - d. Dairy Asian best practice.
6. Ази тивийн сүү үйлдвэрлэлийн индэрийн [www.dairyasia.org](http://www.dairyasia.org) цахим хуудсыг шинэчлэх, тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх;
7. Сүүний чиглэлээр мэргэшсэн эрдэмтэн, судлаачдын цахим сүлжээ зохион байгуулах, судалгааны ажлын мэдээллийн цахим санг үүсгэх, ашиглах;
8. Бүс нутаг, олон улсын хэмжээнд нийгмийн хариуцлагатай хувийн хэвшлийн үндэстэн дамнасан аж ахуйн нэгжүүдтэй түншлэх, урт хугацаанд хамтран ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх;
9. Холбогдох бусад.

...ooOoo...